НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/264/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ундармаа
Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn

Аудитор: Л.Одонтуяа
Утас: 325093 Цахим хаяг: odontuyal@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................................................................................2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..................................4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..........................**Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.................. **Error! Bookmark not defined.**
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин................. **Error! Bookmark not defined.**
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал......... **Error! Bookmark not defined.**
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд **Error! Bookmark not defined.**
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... **Error! Bookmark not defined.**
4. АУДИТЫН ТАЙЛАН...........................................................**Error! Bookmark not defined.**
4.1 Ерөнхий зүйл .................................................... **Error! Bookmark not defined.**
4.2 Материаллаг байдал......................................... **Error! Bookmark not defined.**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ... **Error! Bookmark not defined.**
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **Error! Bookmark not defined.**
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт. **Error! Bookmark not defined.**
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал............ **Error! Bookmark not defined.**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.......................................................................................................10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..........................................24

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НТАГ | Нийслэл дэх төрийн аудитын газар |
| НТГ | Нийслэлийн татварын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| АТӨЯХАТ | Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар |
| БЗД | Баянзүрх дүүрэг |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.05 № 89

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХТУЛГА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж, Нийслэлийн Татварын газраас шилжүүлсэн 7.0 сая төгрөг, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас 231.9 сая төгрөг нийт 238.9 сая төгрөгийн эх үүсвэрийг татварын орлого бүрдүүлэх үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 90.45 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,943,744.94** | **128,138,746.12** |
| **33** | **АВЛАГА** | **2,178,472.00** | **52,055,438.83** |
| **335** | **Бусад авлага** | 2,178,472.00 | 52,055,438.83 |
| **3351** | **Байгууллагаас авах авлага** | 0.00 | 49,876,966.83 |
| **3352** | **Хувь хүмүүсээс авах авлага** | 2,178,472.00 | 2,178,472.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **76,765,272.94** | **76,083,307.29** |
| **354** | **Хангамжийн материал** | **76,765,272.94** | **76,083,307.29** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,486,850.00 | 6,898,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,719,921.83 | 20,799,816.83 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,820,000.00 | 4,190,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 41,738,501.11 | 44,194,690.46 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,313,040,639.37** | **2,486,680,876.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,313,040,639.37** | **2,486,680,876.39** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,284,449,099.37** | **2,458,089,336.39** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,200,513,270.00 | 2,200,513,270.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -336,936,743.61 | -399,226,617.96 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,000,000.00 | 300,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,520,548.30 | -15,693,974.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 538,074,212.64 | 581,167,116.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -203,553,373.21 | -360,788,444.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 414,919,673.00 | 271,019,154.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -350,682,459.41 | -126,245,822.95 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,000,000.00 | 9,600,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -364,931.74 | -2,255,344.09 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **28,591,540.00** | **28,591,540.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,591,540.00 | 28,591,540.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,391,984,384.31** | **2,614,819,622.51** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **3,464,916.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **3,464,916.00** |
| **413** | **Өглөг** | **0.00** | **3,464,916.00** |
| **4136** | **Бусад өглөг** | 0.00 | 3,464,916.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 3,464,916.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,391,984,384.31** | **2,611,354,706.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,391,984,384.31** | **2,611,354,706.51** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | 1,217,304,776.76 | 1,217,304,776.76 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,217,304,776.76 | 1,217,304,776.76 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **983,289,630.03** | **1,202,659,952.23** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 999,501,648.20 | 983,289,630.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -16,212,018.17 | 219,370,322.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 191,389,977.52 | 191,389,977.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,391,984,384.31** | **2,614,819,622.51** |

## 2.2 Аудит хийсэн 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,178,494,148.60** | **5,565,835,843.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **235,764,648.60** | **446,996,743.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **235,764,648.60** | **446,996,743.32** |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 211,764,648.60 | 389,996,743.32 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 211,764,648.60 | 389,996,743.32 |
| 120009 | Бусад орлого | 24,000,000.00 | 57,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,942,729,500.00** | **5,118,839,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **4,576,729,500.00** | **4,832,539,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,576,729,500.00 | 4,832,539,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **366,000,000.00** | **286,300,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 366,000,000.00 | 286,300,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,194,706,166.77** | **5,346,465,521.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,194,706,166.77** | **5,346,465,521.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,031,083,645.23** | **4,961,377,927.49** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,894,948,915.00** | **3,914,066,735.19** |
| 210101 | Үндсэн цалин | 1,868,631,225.00 | 3,914,066,735.19 |
| 210102 | Нэмэгдэл | 725,682,564.00 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 272,026,800.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 1,028,608,326.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **491,907,100.00** | **413,593,370.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 340,879,700.00 | 413,593,370.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 37,756,900.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 18,878,400.00 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,878,400.00 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,513,700.00 | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,666,531.33** | **43,150,063.75** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 19,345,028.75 | 21,208,022.09 |
| 210302 | Түлш, халаалт | 11,998,174.40 | 13,876,168.59 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,323,328.18 | 8,065,873.07 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **117,102,125.74** | **111,184,306.43** |
| 210401 | Бичиг хэрэг | 23,717,900.00 | 21,297,870.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,290,000.00 | 41,340,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 29,795,988.13 | 44,343,436.43 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,858,237.61 | 2,763,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **16,496,250.00** | **24,328,400.00** |
| 210604 | Урсгал засвар | 16,496,250.00 | 24,328,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **126,671,741.00** | **107,134,064.65** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 126,210,745.00 | 106,109,780.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 107,000.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,838.00 | 751,461.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,518.00 | 175,518.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 67,640.00 | 97,305.65 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **345,290,982.16** | **347,920,986.70** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,000,000.00 | 19,805,000.40 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 85,192,000.00 | 54,862,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 248,098,982.16 | 273,253,486.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **163,622,521.54** | **432,087,593.63** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **157,150,900.28** | **36,645,217.28** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 62,850,900.28 | 35,985,217.28 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 94,300,000.00 | 660,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **6,471,621.26** | **395,442,376.35** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,471,621.26 | 347,993,029.34 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 47,449,347.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-16,212,018.17** | **219,370,322.20** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -16,212,018.17 | 219,370,322.20 |

## 2.3 Аудит хийсэн 2025 оны мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 4,943,727,392.74 | 5,118,839,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 4,943,727,392.74 | 5,118,839,100.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 4,576,729,500.00 | 4,832,539,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 4,576,729,500.00 | 4,832,539,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 366,997,892.74 | 286,300,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 366,997,892.74 | 286,300,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | 4,943,727,392.74 | 5,118,839,100.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,943,727,392.74 | 5,118,839,100.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,780,104,871.20 | 4,686,751,506.37 |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,894,948,915.00 | 3,800,289,557.19 |
| 210101 | Үндсэн цалин | 1,868,631,225.00 | 1,943,528,578.04 |
| 210102 | Нэмэгдэл | 725,682,564.00 | 806,677,603.36 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 272,026,800.00 | 321,329,350.00 |
| 210104 | Урамшуулал | 1,028,608,326.00 | 728,754,025.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 492,904,992.74 | 529,367,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 341,877,592.74 | 364,030,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 37,756,900.00 | 41,906,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 18,878,400.00 | 20,953,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 18,878,400.00 | 20,792,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,513,700.00 | 81,685,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 38,666,531.33 | 40,980,063.75 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,709,287.43 | 21,208,022.09 |
| 210302 | Түлш, халаалт | 10,633,915.72 | 11,706,168.59 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,323,328.18 | 8,065,873.07 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 112,134,331.13 | 106,024,732.88 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,800,000.00 | 15,715,020.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,200,000.00 | 42,880,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 23,796,988.13 | 40,723,642.88 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,897,343.00 | 5,266,070.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,650,000.00 | 24,385,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,650,000.00 | 24,385,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 126,538,101.00 | 110,389,552.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 126,144,745.00 | 109,462,573.55 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 107,000.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,838.00 | 751,461.00 |
| 210807 | Газрын төлбөр | 175,518.00 | 175,518.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 97,262,000.00 | 75,314,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,000,000.00 | 19,805,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 85,262,000.00 | 55,509,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 163,622,521.54 | 432,087,593.63 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 157,150,900.28 | 36,645,217.28 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 62,850,900.28 | 35,985,217.28 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 94,300,000.00 | 660,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,471,621.26 | 395,442,376.35 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,471,621.26 | 347,993,029.34 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 47,449,347.01 |

## 2.4 Аудит хийсэн 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 999,501,648.20 | 2,408,196,402.48 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 999,501,648.20 | 2,408,196,402.48 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -16,212,018.17 | -16,212,018.17 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 983,289,630.03 | 2,391,984,384.31 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 983,289,630.03 | 2,391,984,384.31 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 983,289,630.03 | 2,391,984,384.31 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 219,370,322.20 | 219,370,322.20 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,217,304,776.76 | 191,389,977.52 | 1,202,659,952.23 | 2,611,354,706.51 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Батлагдсан төсөв эхний | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,121,845,300.00 | 4,484,546,070.66 | 637,299,229.34 | 87.56% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,121,845,300.00 | 4,484,546,070.66 | 637,299,229.34 | 87.56% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,983,198,300.00 | 4,447,900,853.38 | 535,297,446.62 | 89.26% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | **4,300,897,300.00** | 3,800,289,557.19 | 500,607,742.81 | 88.36% |
| 210101 | Үндсэн цалин | 1,979,311,200.00 | 1,943,528,578.04 | 35,782,621.96 | 98.19% |
| 210102 | Нэмэгдэл | 870,679,700.00 | 806,677,603.36 | 64,002,096.64 | 92.65% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 302,227,200.00 | 321,329,350.00 | (19,102,150.00) | 106.32% |
| 210104 | Урамшуулал | 1,148,679,200.00 | 728,754,025.79 | 419,925,174.21 | 63.44% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 545,888,600.00 | 529,367,600.00 | 16,521,000.00 | 96.97% |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 373,852,700.00 | 364,030,500.00 | 9,822,200.00 | 97.37% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,009,000.00 | 41,906,300.00 | 1,102,700.00 | 97.44% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,504,500.00 | 20,953,100.00 | 551,400.00 | 97.44% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,504,500.00 | 20,792,400.00 | 712,100.00 | 96.69% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 86,017,900.00 | 81,685,300.00 | 4,332,600.00 | 94.96% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 46,990,800.00 | 40,980,063.75 | 6,010,736.25 | 87.21% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 23,940,000.00 | 21,208,022.09 | 2,731,977.91 | 88.59% |
| 210302 | Түлш, халаалт | 14,830,800.00 | 11,706,168.59 | 3,124,631.41 | 78.93% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,220,000.00 | 8,065,873.07 | 154,126.93 | 98.12% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,964,000.00 | 23,644,559.89 | 6,319,440.11 | 78.91% |
| 210401 | Бичиг хэрэг | 9,324,000.00 | 5,625,500.00 | 3,698,500.00 | 60.33% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 400,000.00 | 800,000.00 | 33.33% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,000,000.00 | 14,849,059.89 | (2,849,059.89) | 123.74% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.00 | 1,440,000.00 | - | 100.00% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,000,000.00 | 1,330,000.00 | 4,670,000.00 | 22.17% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,340,000.00 | 3,728,000.00 | 2,612,000.00 | 58.80% |
| 210604 | Урсгал засвар | 6,340,000.00 | 3,728,000.00 | 2,612,000.00 | 58.80% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 45,617,600.00 | 48,601,572.55 | (2,983,972.55) | 106.54% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,200,000.00 | 47,674,593.55 | (2,474,593.55) | 105.47% |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 107,000.00 | - | 107,000.00 | 0.00% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 113,000.00 | 751,461.00 | (638,461.00) | 665.01% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | - | 22,000.00 | 0.00% |
| 210807 | Газрын төлбөр | 175,600.00 | 175,518.00 | 82.00 | 99.95% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,500,000.00 | 1,289,500.00 | 6,210,500.00 | 17.19% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,500,000.00 | 1,289,500.00 | 6,210,500.00 | 17.19% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 36,645,217.28 | (36,645,217.28) | #DIV/0! |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 138,647,000.00 | 36,645,217.28 | 102,001,782.72 | 26.43% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 133,611,000.00 | 35,985,217.28 | 97,625,782.72 | 26.93% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,036,000.00 | 660,000.00 | 4,376,000.00 | 13.11% |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 102.00 | 102.00 | - | 100.00% |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 104.00 | 98.00 | 6.00 | 94.23% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6.00 | 2.00 | 4.00 | 33.33% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 101.00 | 101.00 | - | 100.00% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 98.00 | 98.00 | - | 100.00% |
| 650009 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 3.00 | - | 100.00% |

## 2.6 Аудит хийсэн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **286,300,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **286,300,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **238,850,652.99** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **82,380,172.99** |
| 210401 | Бичиг хэрэг | 10,089,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 42,480,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,874,582.99 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,936,070.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,657,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 20,657,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **61,787,980.00** |
| **210801** | **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 61,787,980.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **74,025,000.00** |
| **210901** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,805,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 54,220,000.00 |
| **212** | **ТАТААС** | **47,449,347.01** |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | **47,449,347.01** |
| **212101** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 47,449,347.01 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **286,300,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **286,300,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 286,300,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 2,932.8 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

**Залруулсан алдаа:**

- Зардлын эдийн засгийн ангиллыг 2,370.0 мянган төгрөгөөр буруу илэрхийлж үр дүнгийн тайланд тусгасныг:
- Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй 562.8 мянган төгрөгийн орлогыг өөрийн орлогоор тайлагнасныг:

Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НБББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-д *“Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх”*, санхүүгийн тайлагналын “*тохиолдсон байх*”, “*толилуулга*” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “*Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна*” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 21,178.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 21,178.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 21,178.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 56,742.1 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

1. Татвар төлөгчдийн зан төлвийг тодорхойлох судалгааны ажлыг 19,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*”, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Ажлаас гарсан ажилчидтай холбоотой, авлагын насжилт өндөртэй 2,178:5 мянган төгрөгийн авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”*, 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;”*, 20.2.5-д *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”*, Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 6 дугаар бүлгийн 6.6-д "*Байгууллага арилжааны ажил гүйлгээний үр дүнд бий болсон авлагын үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа өмнөх жилүүдийн туршлагад үндэслэн авлагын эргэн төлөлтөд нөлөөлж болох доорх хүчин зүйлсийг харгалзан хувь хэмжээг тогтооно:, (г) авлага нь төлөгдөх хуваарьт өдрөөс хойш 1 жилээс дээш хугацаанд хөдөлгөөн хийгдээгүй; (д) төлбөр хариуцагч гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй байх бусад тохиолдол, нөхцөлүүд, тэдгээрт байгууллагын зүгээс авах арга хэмжээ*", 6.7-д "*Шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн төлөгдөх найдваргүй болсон авлагыг данснаас хасаж болно.*" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Авлагын барагдуулах арга хэмжээг зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгөв.

**3.2 Зөвлөмж**

1. Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Татварын Ерөнхий Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/04 дүгээр тушаалтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "*нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодогчид өөр ажил хавсруулан ажиллуулахгүй байх, нягтлан бодох бүртгэлийн хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд нэр данс зөрүүтэй орлогыг орлогоор тайлагнасан | 1 | 562.8 | - | - | 1 | 562.8 | 1 | 562.8 | - | - |
| Зардлын эдийн засгийн ангилал буруу илэрхийлж үр дүнгийн тайланд тусгасан. | 1 | 2,370.0 | - | - | 1 | 2,370.0 | 1 | 2,370.0 | - | - |
| **Дүн** | **2** | **2,932.8** | **-** | **-** | **2** | **2,932.8** | **2** | **2,932.8** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Татвар төлөгчдийн зан төлөвийг тодорхойлох судалгааны ажил хийлгэж төсвийг үрэлгэн зарцуулсан. | 1 | 19,000.0 | | | 1 | 19,000.0 | | |
| Ажлаас гарсан ажилчидтай холбоотой, авлагын насжилт өндөртэй авлагыг шийдвэрлэх талаар арга хэмжээ аваагүй | 1 | 2,178.5 | | | 1 | 2,178.5 | | |
| Нягтлан бодогчийн орон тоо батлагдсан боловч, улсын байцаагч хавсран гүйцэтгэж байгаа нь нягтлан бодох бүртгэлд тавих хяналтыг сулруулах эрсдэлийг үүсгэж байна. | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 |
| Дүн | **2** | **21,178.5** | - | - | **2** | **21,178.5** | 1 | 0.00 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийх ажлаа гүйцэтгэхийн тулд харьяа дүүргээс нэмэлт санхүүжилтийн дансаар мөнгө авч зарцуулсан. | 1 | 238,850.7 | | | - | - | 1 | 238,850.7 |
| Дүн | **1** | **238,850.7** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **238,850.7** |